

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2016 ОНЫ 14 ДҮГЭЭР ХУРАЛДААН**

Хуралдаан 2016 оны арван хоёр дугаар сарын 01-ны 10 цаг 05 минутад эхэлж, 11 цаг 02 минут хүртэл Засаг даргын Тамгын газрын даргын өрөөнд болж, нийт 57 минут үргэлжлэв.

№	Хэлэлцэх асуудлын төлөвлөгөө	Шийдвэр
1	Л.Өлзий-Отгоны өргөдлийг хянан шийдвэрлэх комиссын дүгнэлтийн тухай	“Л.Өлзий-Отгоныг ажлаас чөлөөлөх тухай” аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2016 оны 10 сарын 03-ны өдрийн Б/16 тоот тушаалыг эс зөвшөөрч Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын мэргэжилтнээр ажиллаж байсан Л.Өлзий-Отгоны салбар зөвлөлд гаргасан гомдлыг хянан шалгасан Маргаан хянан шийдвэрлэх комиссын дүгнэлтийг зүйтэй гэж үзэж тогтоол гаргахаар шийдвэрлэв.
2	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Говь-Угтаал сум хариуцсан мэргэжилтний ажлын байранд нөөцөөс нэр дэвшүүлэх тухай	Говь-Угтаал сум хариуцсан мэргэжилтний албан тушаалд 2016 оны 10 дугаар сард явагдсан төрийн албаны мэргэшлийн шалгалтанд 62,7 оноогоор тэнцэж, Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 11 сарын 04-ний өдрийн 157 дугаар тогтоолоор төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэгдсэн Нацагдорж овогтой Өлзийтогтохыг нэр дэвшүүлэхээр шийдвэрлэж, албан тоотоор хүргүүлэхээр болов.
3	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын албан тушаалд сонгон шалгаруулсан Н.Эрдэнэ-Очирын талаар дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын албан тушаалд нэр дэвшүүлж буй Норовжав овогтой Эрдэнэ-Очирын дүгнэлтийг ТАСЗ-ийн тогтоолоор баталгаажуулж, албан тоотоор хүргүүлэхээр шийдвэрлэв

САЛБАР ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБА